

Тайлбар, тодруулга өгөх тухай

1. Эмнэлэг тусламж, үйлчилгээнийхээ тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн үйлчлүүлэгчийн эмчилгээнд хэрэглэх S0433 кодтой “Микрокатетр” –ийн хэмжээг тогтоон Нийлүүлэгчид захиалгаа өгөхөөр тооцон уг хэрэгслийн хэмжээг 1.9Fr – 2,8Fr байхаар заасан бөгөөд энэ хэрэгслийн хэмжээ, тоог урьдчилан хатуу тогтоож Тендерийн баримт бичигт тусгах боломжгүй байна.

Захиалагч/ эмнэлэг/ “Хэвлийн ангиогийн гуурс, чиглүүлэгч” гэсэн 22 дугаар багцын 3-д байгаа S0433 кодтой “Микрокатетр” -ээс худалдан авах тоо ширхэгийг эмчилгээний хэрэгцээ, шаардлагаас хамааран тооцсон бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 07 дугаар тогтоолд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх S0433 кодтой “Микрокатетр” –ийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаарыг тухайн эмнэлгийн хэрэгслийн хэмжээнээс хамаарахгүй байхаар тогтоосон байна.

2. Тус эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээний чанар, үр дүн болон тендерт оролцогчдын шударга өрсөлдөөнийг дэмжих, хязгаарлахгүй байх зорилгоор “Гахайн сүүл” гэсэн нэртэй 23 дугаар багцын SO378 кодтой Гахайн сүүл гуурсыг хатуу болон зөөлөн бүтэцтэй байхаар заасан бөгөөд ямар бүтэцтэй хэрэгсэл санал болгох нь танай байгууллагын сонголт ба хэмжээс тус бүрийн тоо өгөгдсөн байгаа болно.

3. Багц 26 “Захын судасны ангиографийн хэрэгсэл”-н №2 Чиглүүлэгч сэтгүүр гидрофиль /Hydrophilic Guidewire/, №3 Чиглүүлэгч хатуу (guidewire stiff) -ийн техникийн тодорхойлолт нь нийтлэг тодорхойлолт бөгөөд аль нэг компани болон брэндийн үзүүлэлтийг тавих боломжгүй болно.

№ 5 Доод хөндийн венийн (IVC) фильтр-ийн техникийн тодорхойлолтод 6F-7F голчтой гэсэн нэмэлт оруулж байна.

4. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 27 болон 28 дугаар зүйлийн дагуу тендерт оролцогчдийн баримт бичигтэй танилцсаны дараа Тендерийг хянаж үзэх, Тендерийг үнэлэх гэсэн үе шаттайгаар шалгаруулалт явагдах тул хямд үнэтэйг сонгоно гэсэн ойлголт байж болохгүй болно. 2020 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Багц 39. “Стентийн дагалдах хэрэгсэл”-ийн Дамжуулагч гуурс / introducer/-ийн хэмжээсний хувьд тодруулга хийсэн бөгөөд энэ нь тендерт оролцогчдоод ижил тэгш эрх олгож байна гэж бид үзэж байна.

5.Багц 42. SO137 кодтой Судасны нүх бөглөгчийн оронд S0188 кодтой “Судас боох багц”-ыг санал болгох боломжгүй болно. S0188 кодтой “Судас боох багц” нь Олон улсын өвчний код(ICD-10) болон Үйлдлийн олон улсын ангилал(ICD9)-аараа ялгаатай юм.

6.Багц 46. SO513 кодтой нэг хөндийт “Микрокатетер”-ийн техникийн тодорхойлолт, үзүүлэлт нь дан ганц IMDS Service BV компанийн бүтээгдэхүүнийх биш бөгөөд бусад компаниудын техник үзүүлэлт, бүтээгдэхүүний танилцуулгатай дүйцэж байгаа тул тухайн хэрэгсэлийн техникийн үзүүлэлтийг тодруулах шаардлагагүй болно.

7.ТОӨЗ-ийн 18.1-ийн “а”-д заасан “Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл”-д гэрээт борлуулагчийн итгэмжлэлийг Үйлдвэрлэгч байгууллагаас эрх олгосон зөвшөөрөл /итгэмжлэл/-ийн хамт байгаа тохиолдолд адилтгаж үзнэ.

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН

“ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЗАРИМ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ
ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ПРОТЕЗ ХУДАЛДАН АВАХ “ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО